

ШУУДАН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЭЛТСИЙН ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Э.ОЮУН-ЭРДЭНИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ 1. “ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1	Арга хэмжээ 1.1. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг эхлүүлэх;	Хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тоо	-	Сангийн үйл ажиллагаа эхэлсэн байна	Биелэлт: Сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг батлахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3 дахь заалтад заасан багцад хуваах, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтад заасан тендер хүлээн авах доод хугацааг баримтлан Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/06 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 3 зорилт, 4 арга хэмжээтэйгээр, Хоёрдугаар хавсралтаар 1,962,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төрлийн ажил, арга хэмжээг санхүүжүүлэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн өдрийн А/27 дугаар тушаалын хавсралтаар "хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г "Хүнсний аюулгүй байдлын талаарх	2024.01.15 – 2024.12.15	70%

				мэдээллийг олон нийтэд таниулан сурталчлах танин, мэдэхүйн цуврал контент бэлтгэх" арга хэмжээг нэмж, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өрийн А/30 дугаар тушаалын хавсралтаар "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г 19,620,000 төгрөгийн төсөвт өртөгтэй 100 төрлийн төсөл, арга хэмжээ болгон хувааж, шууд худалдан авахаар төлөвлөгөөг дахин боловсруулж батлуулсан. Авлигатай тэмцэх газраас 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан"-гийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, сонгон шалгаруулалт, орон тооны бус Хяналтын зөвлөл, ажлын хэсгийн үйл ажиллагаа болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, холбогдох мэдээ, мэдээллийг хуульд заасан хэлбэрээр олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэж буй байдалтай танилцах төлөвлөгөөт хяналт шалгалт орж, холбогдох зөвлөмжийг 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн бөгөөд Зөвлөмжид дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэн Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/398 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.1.2.2, 3.2.1-т заасныг тус тус үндэслэн Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн төрийн сангийн данс нээх хүсэлтийг 2024 оны 03/1083 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүсэлт хүргүүлж, 100900067006 данс нээлгэсэн. Шилэн дансны хууль тогтоомж, журмын дагуу Шилэн дансны цахим системд Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хэрэглэгчийн эрхийг нээлгэж, 2024 оны мэдээллийг байршуулсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалт, "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм"-	
--	--	--	--	---	--

					ийн 2.1.1, 2.1.2-т заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүрээгүй алслагдсан орон нутгийн хүн амд үйлчилгээ хүргэх зорилгоор дамжуулах сүлжээний үйлчилгээ үзүүлэх сангийн хөрөнгийн 15 хувийг, үйлдвэрлэхэд өртөг өндөр контентын агуулгыг төлөвлөгөөнд тусган 3 зорилтын хүрээнд тендер зарлан зохион байгуулахаар төлөвлөгөөг хууль, журамд нийцүүлэн БТГ-тай хамтран шинэчлэн боловсруулж 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.		
1.2	Дэд арга хэмжээ 1.1.1 Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн Хяналтын зөвлөлийн тушаал батлуулах, Хяналтын зөвлөлийн хурлыг улирал бүр зохион байгуулах;	Батлуулсан тушаал Зохион байгуулсан хурлын тоо	-	4	Биелэлт: Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хэрэгжилтийн хүрээнд ЦХХХ-ны Сайдын 2024 оны А/02 дугаар тушаалаар Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлуулж, Хяналтын зөвлөлийн 2024 оны нэгдүгээр улирлын хурлыг 02 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Тус хурлаар Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэж, Хяналтын зөвлөлийн даргыг санал хураалтаар сонгосон. “Монголын арилжааны телевизүүдийн дуун холбоо” ТББ-аас ирүүлсэн саналын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр ЦХХХ-ны сайдын А/71 тушаалаар хяналтын зөвлөлийн гишүүнийг өөрчлөн шинэчлэн батлуулсан. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дүрэм, журмыг шинэчлэн батлуулахтай холбогдуулан Сангийн дарга хяналтын зөвлөлийн хурал хийхийг хойшлуулсан.	2024.01.15 – 2024.12.15	70%
1.3	Дэд Арга хэмжээ 1.1.2 Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг байгуулах;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо			Биелэлт: Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаартай “Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын даалгавар боловсруулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулагдсан. 2024 оны 02 дугаар сарын	2024.01.15 – 2024.12.15	

					21, 03 дугаар сарын 18, 04 дүгээр сарын 03-ний өдөр тус тус зохион байгуулж хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулсан. Ажлын хэсгээс 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх, үйлдвэрлэхэд өртөг өндөр үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн контент үйлдвэрлэл, өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн бүтээл үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангаас 2024 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 30 хоногийн хугацаатай байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд зарласан. Тус ажлын хэсэг нь нийт 3 удаа хуралдсан бөгөөд Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх, үйлдвэрлэхэд өртөг өндөр үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн контент үйлдвэрлэл, өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн бүтээл үйлдвэрлэлийг дэмжих зорилготой Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах удирдамж болон гэрээний төслүүдийг боловсруулсан. Сонгон шалгаруулалтыг Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн 2024 оны төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд зааснаар доорх төрлөөр Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.5 дахь заалтад заасан үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд хамрагдахаар зарласан. Радио, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс тус сонгон шалгаруулалтад нийт 55 төсөл ирүүлсэн. 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Авлигатай тэмцэх газраас Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх санд төлөвлөгөөт шалгалт орсонтой холбогдуулан сонгон шалгаруулалтыг түр зогсоож сангийн хөрөнгөнөөс зарцуулалт гаргахгүй болно.		100%
1.4	Арга хэмжээ 1.2. Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн контентын хөгжлийн	Хэрэгжилтэд хийсэн	-		Биелэлт: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалтын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 01 дүгээр сарын	2024.01.15 – 2024.12.15	

	бодлого, журам, дүрэм, зөвлөмж, стандартын хэрэгжилтийг хангах;	үнэлгээний тоо		1	04-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар батлагдсан "Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газартай хамтран өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр гамшгийн үеийн мэдээлэл дамжуулах нэгдсэн системийн холболтын цэгт Монголсат Нэтворк ХХК-ыг холбосон. Мөн Онцгой байдлын ерөнхий газар, Олон суваг эрхлэгчдийн холбооны төлөөллүүдтэй 2024 оны 10 дугаар сарын 14-ны өдөр уулзалтыг зохион байгуулж, Юнивишн ХХК болон Скаймедиа ХХК-уудад 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр дээрх журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 03/850 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.		100%
--	---	----------------	--	---	--	--	------

ЗОРИЛТ 2. “РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

2.1	Арга хэмжээ 2.1. “Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний хэрэгжилтэд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх;	Хяналт, шалгалтын тоо	Улирал бүр хяналт хэрэгжүүлэх	4	Биелэлт: “Сансрын холбооны кей юү (KU) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний хүрээнд тус яамны сайдын 2022 оны 02 сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан “Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний хяналтын журам”-ын хоёрдугаар хэсгийн дагуу хяналтын комисс нь Нэгдүгээр улирлын хэмжилт, шалгалтыг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, Хоёрдугаар улирлын хэмжилт, шалгалтыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Гуравдугаар улирлын хэмжилт, шалгалтыг 09 дүгээр сарын 23-ны өдөр, Дөрөвдүгээр улирлын хэмжилт, шалгалтыг 11 дүгээр сарын 28-ны өдөр МХС ТӨК-ийн Наран станцад байрлах /МОНГОЛСАТ НЭТВОРКС ХХК/ газрын станц дээр тус тус хийж тайланг тухай бүр боловсруулан СХОХ-д хүргүүлсэн.	2024.01.15 – 2024.12.15	100%
-----	--	-----------------------	-------------------------------	---	--	-------------------------	------

2.2	Арга хэмжээ 2.2. Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын орон нутаг дахь станцуудын хамрах хүрээ, одоогын нөхцөл байдалд үнэлгээ хийх;	Хяналт шалгалтын тоо	-	2	Биелэлт: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д "өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг ард иргэдэд алслагдсан, сүлжээ хүрээгүй газарт хүртээмжтэй хүргэх" гэж заасан зорилгын хүрээнд Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын орон нутаг дахь станцуудын хамрах хүрээ, одоогийн нөхцөл байдлын хэмжилтийг 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 03/458 дугаартай хамтран хэмжилт хийх албан бичгийг хүргүүлж 2024 оны 10 сарын байдлаар тоон телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээнд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 33 тусгай зөвшөөрлийн радио станцуудад ATDI NTZ Communication спектр инженерчлэлийн программ хангамжаар хамрах хүрээний тооцоолол хийсэн.	2024.06.15 – 2024.12.15	100%
ЗОРИЛТ 3. "ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
3.1	Арга хэмжээ 3.1.Өргөн нэвтрүүлгийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;	Салбарын байгууллагатай хамтран ажилласан байна. Сургалт зохион байгуулсан байна.	-	1	Биелэлт: "Өргөн нэвтрүүлгийн шийдэлтэй уулзалт" сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн Сайдын танилцуулга, хөтөлбөрийг боловсруулж, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч оролцогчдын нэрсийг гарган, Новотел зочид буудалд зохион байгуулахаар ажилласан боловч Сайдаас өгсөн чиглэлийн дагуу цуцалсан.	2024.06.10- 2024.12.15	30%
ЗОРИЛТ 4. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 4.1. Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж батлуулах, тайлагнах;	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо, ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо,	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо - 1	ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо - 1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, нэгжийн удирдлагаар батлуулж, батлагдсан загварын дагуу биелэлтийг гаргасан.	2024.01.15 – 2024.12.15	100%

			лийн биелэлт ийн тоо - 1				
2	Арга хэмжээ 4.2. Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна.	Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.	2024.01.01 – 2024.12.15	100%
3	Арга хэмжээ 4.3. Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх	-	-	Нийт 42 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан.	2024.01.01 – 2024.12.15	100%
4	Арга хэмжээ 4.4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх;	Хууль болон холбогдох журамд нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөж, архивын нэгж үүсгэсэн эсэх	-	Баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивласан байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөн ажиллаж байна.	2024.01.01 – 2024.12.15	100%
5	Арга хэмжээ 4.5. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь	-	Тухай бүр	Тайлант хугацаанд 12 иргэнээс гомдол ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	2024.01.01 – 2024.12.15	100%

	цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх;	шийдвэрлэсэн тоо					
6	Арга хэмжээ 4.6. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг хангах;	Тухай бүр	-	Тухай бүр	ХАСХОМ-ийг 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн гаргасан байна. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн мэдүүлсэн.	2024.01.01 – 2024.12.15	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах;	Хууль батлуулах	-	Хуулийг төслийн эцэслэн батлуулсан байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж тус хуулийн 25 дугаар зүйл "Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал" хэсгийг ХХЗХороотой хамтран боловсруулж 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлуулсан.	2024.01.17	100%
2.	Үүрэг даалгавар 2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд боловсруулагдах журмын төслүүдэд санал өгөх;	Боловсруулагдан гарч байгаа журмын төсөлд санал өгөх	-	1	Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн "Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага", "Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам" болон "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журам"-ын төслүүдэд санал боловсруулж БТГ-т хүргүүлсэн.	2024.02.05	100%
3.	Үүрэг даалгавар 3.				Мэдээлэл технологийн салбарын охидын өдрийг "ICT GIRLS" уриалгын хүрээнд Цахим хөгжил, харилцаа	2024.04.17	100%

	Мэдээлэл технологийн салбарын охидын өдрийг тэмдэглэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах;	Арга хэмжээ зохион байгуулах	-	1	холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр мэдээллийн технологийн салбарт охидын оролцоог дэмжих, нэмэгдүүлэх зорилгоор технологийн салбарын мэргэжил, онцлог, давуу талын талаар ойлголт мэдээлэл өгөх, цахим орчинд эрхээ хэрхэн хамгаалах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт ШУТИС, ХААИС, АУШИС төлөөлөл болсон 150 гаруй оюутан сурагчид оролцсон.		
4.	Үүрэг даалгавар 4. Гадаад томилолтоор ажиллах;	Томилолтоор ажиллах	-	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/108 дугаар тушаалаар Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллага (АРТ)-аас Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулах "Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын олон улсын хуралд бэлтгэх нь" сэдэвт сургалтад хөтөлбөрийн дагуу оролцсон. Тус сургалтад 15 гаруй орны цахим яам, мэдээллийн технологийн төрийн байгууллагын төлөөллүүд оролцсон. Гадаад томилолтын тайланг ГХАХэлтэсд хүргүүлсэн.	2024.05.07- 2024.05.10	100%
5.	Үүрэг даалгавар 5. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хийх хил орчмын радио давтамжийн зохицуулалтын уулзалт, хэлэлцээг зохион байгуулах;	Арга хэмжээний тоо	-	1	Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хийх хил орчмын радио давтамжийн зохицуулалтын уулзалт, хэлэлцээг 2024 оны 5 дугаар сарын 21-нээс 23-ний өдрүүдэд Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан. Зохион байгуулалтын багт орж ажилласан.	2024.05.21- 2024.05.23	100%
6.	Үүрэг даалгавар 6. Шуудан өргөн нэвтрүүлгийн хэлтсийн төлөвлөгөөний 1.2	Арга хэмжээ зохион байгуулах	-	2	1.Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтэс, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран Монгол Улсын цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдал, цахим худалдаа болон шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн	2024.06.04	100%

	Шуудан, цахим худалдааны тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах;				үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, боломж, төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар мэдээлэл солилцох зорилгоор цахим худалдаа эрхлэгч, программ хөгжүүлэгч болон төрийн байгууллагын төлөөлөл оролцсон "Цахим худалдаанд үзүүлэх дэмжлэг" хэлэлцүүлгийг 2024 оны 6-р сарын 04-ний өдөр зохион байгуулсан. "Цахим худалдаанд үзүүлэх дэмжлэг" хэлэлцүүлэгт ЦХХХЯ, ГХЯ, ХХЗХ, Монгол банк, ГЕГ, ТЕГ, УХШИГГ, И-Монголиа УТҮГ, "Монгол инфинити шуудан" ХХК, "Пик пак ворлдвайд" ХХК, "Стора централ" ХХК, "Альфа лабс" ХХК зэрэг цахим худалдаа, цахим платформ, хүргэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч компаниуд илтгэл танилцуулж оролцсон. 2. Монгол Улсын шуудангийн салбарын өнөөгийн хөгжлийн шаардлага, хууль эрх зүйн орчны талаар хэлэлцэх "Шуудангийн шинэчлэл" дугуй ширээний уулзалт арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Блю скай зочид буудлын Jade хурлын танхимд 09:00-12:00 цагийн хооронд зохион байгуулсан. Уулзалтад Харилцаа холбооны зохицуулах хороо, Монгол шуудан ХК, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Тагнуулын Ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Авто Тээврийн Үндэсний төв, И-Монгол академи УТҮГ, Шуудангийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн холбоо, Шуудангийн үйлчилгээ эрхлэгч Аж ахуйн нэгжүүд зэрэг төр, хувийн хэвшлийн 26 байгууллагын 52 төлөөлөл оролцсон.		
7	Сансрын холбооны Кей Юү (КУ) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээний өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах	Тайлангийн тоо	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/10 дугаар тушаалаар Сансрын холбооны Кей Юү (КУ) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээний өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал	2024.08.30- 2024.11.08	100%

	үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж тайлан боловсруулах				боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Сайдад танилцуулсан.		
8	"Хүүхэд хамгааллын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.13-д заасан "Энэ хуулийн 25.12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам"	Журмын төсөл боловсруулах	-	1	"Хүүхэд хамгааллын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.13-д заасан "Энэ хуулийн 25.12-т заасан орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам" Засгийн газрын тогтоолын төслийг 2024 оны 12 дугаар сарын 05-нд ХХЗХороотой хамтран боловсруулсан.	2024.08.30-2024.12.05	100%
9	"Хүүхэд хамгааллын тухай хууль"-ийн 25.11-д заасан "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ын төслийг эцэслэн боловсруулах	Журмын төсөл боловсруулах	-	1	"Хүүхэд хамгааллын тухай хууль"-ийн 25.11-д заасан "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ын төслийг ХХЗХ-той хамтран боловсруулсан.	2024.08.30-2024.12.05	100%
10	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд тайлан хүргүүлэх	Тайлангын тоо	-	1	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай" 03 дугаар тогтоолын хэрэгжилт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенц, тухайн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагаа салбар бүрд цаашид хэрэгжүүлэх чиглэл, арга хэмжээний зөвлөмжийн явцын тайланг munkhtsetseg@cfga.gov.mn цахим шуудангаар 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хүргүүлсэн.	2024.09.05	100%
11	Хүүхэд хамгаалал нөлөөллийн аян зохион байгуулах	Арга хэмжээ	-	1	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх мэдлэг, мэдээлэл олгох, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, олон нийтийн дунд үе тэнгийн дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, энэ төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оны 09 дүгээр сарын 21-ны өдрөөс 2024 оны 10-р сарын 21-ны өдрүүдийн хооронд "НАЙЗ БАЙЯ"-2 үндэсний аяныг ХНХЯам, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Харилцаа холбооны зохицуулах хороо тус тус хамтран зохион	2024.09.21-2024.10.21	100%

					байгуулсан.Тус яамны зүгээс Мэдээлэл холбооны сүлжээ ХК-нд 03/447 дугаартай хамтран ажиллах тухай албан бичгийг 2024 оны 10 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлж төв байрны цагтай цамхгийн доор байрлах сурталчилгааны самбарт аяны постерыг байршуулж олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Чиг үүргийн хүрээнд сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдах	-	Тухай бүр	1. ТА3-аас зохион байгуулж байгаа 7:4:10 –ийн зохион байгуулагдсан сургалтад тухай бүр хамрагдсан. 2. Төрийн албан хаагчийн дунд хугацааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдаж төгссөн. 3. "Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын олон улсын хуралд бэлтгэх нь" сэдэвт сургалтад 2024 оны 05 дугаар сарын 05-10-ны өдрүүдийн хооронд сургалтын хөтөлбөрийн дагуу оролцсон.	2024.01.01 – 2024.12.15	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН
ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ШИНЖЭЭЧ
(Албан тушаал)

 / Э.Оюун-Эрдэнэ /
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)